



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, ерөнхий эргүүл, хариуцлагатай эргүүл жижүүр томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.4, 32.1.10 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 134 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сар шинийн баяр амралтын өдрүүдэд 2018 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн 09:00 цагаас мөн оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд дүүргийн Засаг даргын Тамгын газарт үүрэг гүйцэтгэх ерөнхий эргүүл, хариуцлагатай жижүүрүүдийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх өдрүүдэд Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгж, хорооны Засаг дарга нар тус тусын хариуцсан объект, нутаг дэвсгэрт хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулж, үүрэг гүйцэтгэлийн тухай дүүргийн хариуцлагатай жижүүр /70120320/ дугаарын утсанд 09:00-21:00 цагийн хооронд илтгэж ажиллахыг даалгасугай.

3. Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн цагийн байдал үүссэн нөхцөлд ард иргэдийн амь нас, өмч хөрөнгийг авран хамгаалах ажлыг шуурхай зохион байгуулж бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс /хурандаа А.Батмөнх/, Цагдаагийн нэгдүгээр хэлтэс /цагдаагийн хурандаа Б.Буянтөр/, Цагдаагийн хоёрдугаар хэлтэс /цагдаагийн хурандаа Г.Цэргийнхүү/, Замын цагдаагийн хэлтэс /цагдаагийн хурандаа Ц.Ариунболд/, Мэргэжлийн хяналтын хэлтэс /Б.Нарангэрэл/, Эрүүл мэндийн төв /Ө.Батжаргал/, УБЦТСХК харьяа Баянгол Хэрэглэгчдэд үйлчлэх төв /Б.Сүх-Эрдэнэ/, ОСНААУГ-ын харьяа Баруун түгээх төв /М.Оюунболд/, Төв түгээх төв /Б.Оюунчулуун/, Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ /Б.Мөнгөнсүх/, хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Баярын өдрүүдэд ажиллах эргүүл, жижүүрт олгох хоол, холбоо болон бусад зардалд шаардагдах 180,000 /зуун наян мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ахлах нягтлан бодогч /Б.Хонгорзул/-д зөвшөөрсүгэй.